



МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ШУУДАН,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2014 оны 03 сарын 03 өдөр

Дугаар 72

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 91.1 дэх хэсэг, Засгийн газрын 2012 оны 137 дугаар тогтоолоор батлагдсан “Үндэсний хиймэл дагуул” хөтөлбөрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Ази номхон далайн сансрын хамтын ажиллагааны байгууллагаас зарлагдсан БНХАУ-ын Бейханы их сургуулийн 2014-2015 оны хичээлийн жилд сансар, радио холбооны чиглэлээр магистр болон докторын тэтгэлэгт хөтөлбөрийн анхан шатны сонгон шалгаруулалтыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын хэсгийн удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Ажлын хэсгийн үйл ажиллагааг удирдамжийн дагуу зохион байгуулж, үр дүн, тайланг газрын удирдлагад танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Алтансүх/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЖАДАМБАА

110769

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын даргын 2014 оны 03 сарын 03 өдрийн 72 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



АЗИ НОМХОН ДАЛАЙН САНСРЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨРИЙН АНХАН ШАТНЫ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ ЯВУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:

Б.Алтансүх Төрийн захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газрын дарга

Нарийн бичгийн дарга:

П.Ариунтуул Төрийн захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газрын мэргэжилтэн

Гишүүд:

В.Батбаяр Шинэчлэлийн бодлого, төлөвлөлтийн газрын Сансар, радио холбооны хэлтсийн дарга

Ч.Нургул Харилцаа холбоо, дэвшилтэт технологийн ажлын албаны ахлах мэргэжилтэн


Н.Цэвээндарь Төрийн захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газрын ахлах мэргэжилтэн

Ш.Хандмаа Төрийн захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газрын ахлах мэргэжилтэн

А.Уранчимэг Шинэчлэлийн бодлого, төлөвлөлтийн газрын Сансар, радио холбооны хэлтсийн мэргэжилтэн

Н.Бат-Энэрэл Харилцаа холбоо, дэвшилтэт технологийн ажлын албаны мэргэжилтэн

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны
газрын даргын 2014 оны 3 сарын 03 өдрийн 72 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН ЕРӨНХИЙ УДИРДАМЖ

Зорилго: Ази номхон далайн сансрын хамтын ажиллагааны байгууллага /АНДСХАБ/-аас зарлагдсан 2014-2015 оны хичээлийн жилд БНХАУ-ын Бейханы их сургуульд сансар, радио холбооны чиглэлээр магистр /6/ болон докторын /1/ тэтгэлэгт хөтөлбөрийн анхан шатны сонгон шалгаруулалтыг АНДСХАБ-ын APSCO/2014/ET&DM/002e тоот ноотын дагуу зохион байгуулах

Хугацаа: 2014 оны 3 дугаар сарын 03-наас 10-ны өдөр хүртэл

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Сонгон шалгаруулалтад ирүүлсэн материалын иж бүрдэлтэй судалж танилцах
2. Сонгон шалгаруулалтад оролцохоор өргөдөл гаргагчидтай ярилцлага зохион байгуулах /ярилцлагын сэдвийг бэлтгэж газрын даргад танилцуулсан байх/
3. Сонгон шалгаруултад ирүүлсэн материалын иж бүрдлийн болон ярилцлагын дүнг гаргах
4. Анхан шатны сонгон шалгаруулалтад тэнцсэн оролцогчдыг газрын удирдлагад танилцуулах
5. Тэнцсэн оролцогчдын материалыг Ази номхон далайн сансрын хамтын ажиллагааны байгууллагад хүргүүлэх

Тайлан: Ажлын хэсгийн тайланг 2014 оны 3 дугаар сарын 15-ны өдөр газрын удирдлагад танилцуулна.